ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: САГ-2026/24/НА-СТА-ТЕЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор Д.Баярсайхан<br>Утас: 261663 Цахим хаяг: Bayarsaikhand@audit.gov.mn<br>Аудитын менежер Б.Долгорсүрэн<br>Утас: 261740 Цахим хаяг: Dolgorsurenb@audit.gov.mn<br>Ахлах аудитор П.Амарсанаа<br>Утас: 261648 Цахим хаяг: Amarsanaap@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ..... 6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..... 7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 15
3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал ..... 15
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин ..... 15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 16
3.4.1 Мөнгөн хөрөнгө ..... 16
3.4.2 Авлага ..... 17
3.4.3 Урьдчилгаа ..... 18
3.4.4 Бараа материал ..... 19
3.4.5 Нөөцийн бараа ..... 20
3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө ..... 20
3.4.7 Үндсэн хөрөнгө ..... 20
3.4.8 Өр төлбөр ..... 21
3.4.9 Засгийн газрын хувь оролцоо ..... 22
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 23
3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... 23
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... 23
3.5.3 Улсын төсвийн орлого бүрдүүлэлт ..... 25
3.5.4 Нэмэлт төсөв ..... 25
3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ..... 25
3.5.6 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт ..... 26
3.5.7 Тайлант жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл ..... 29
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 30
4.1 Ерөнхий зүйл ..... 30
4.2 Материаллаг байдал ..... 30
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 30
4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 30
4.3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 30
4.3.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ..... 31
4.4 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 31
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 32
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 33
5.1 Албан шаардлага ..... 33
5.2 Зөвлөмж ..... 34
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 36

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ГИХГ | Гадаад иргэн харьяатын газар |
| ГХУСАЗЗАА | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба |
| ТБАНТХ | Төрийн болон албаны нууцын тухай хууль |
| ТӨААТҮГ | Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар |
| ТӨДХХК | Төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ТТАХНЭ | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг |
| ТХ | Төвлөрсөн хангалт |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХЕГ | Хил хамгаалах ерөнхий газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХЦ | Хилийн цэрэг |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ШШГГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| ШШЕГ | Шүүх шинжилгээний ерөнхий газар |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот,15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.27 № 1139

танай ____________-ны № ____________-т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД С.АМАРСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн нэгтгэсэн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Эрх зүйн, хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд Хууль бус хөрөнгө хураах тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Хүний эрхийг хангахтай холбоотой зарим хууль, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл, Арилжааны тухай хуулийн төсөл, Шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газраар хэлэлцүүлж, зарим хуулийн төслүүдийг Улсын Их Хурлаар батлуулсан байна. Мөн хуулийн төслийн үзэл баримтлал, үр нөлөө зардлын тооцоо, судалгаа хийх ажилд Хууль зүй, дотоод хэргийн яам 221.4 сая төгрөг, Хууль зүйн үндэсний хүрээлэн 110.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3-т заасан зохицуулалтын хүрээнд төрийн байгууллага, ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлын нөхөн төлбөр 2023 онд 6.8 тэрбум төгрөгийг 129 иргэн, хуулийн этгээдэд, 2024 онд 4.3 тэрбум төгрөгийг 140 иргэн, хуулийн этгээдэд, 2025 онд 19.5 тэрбум төгрөгийг 134 иргэн, хуулийн этгээдэд олгож, хохирол, төлбөрийг барагдуулсан бөгөөд 2026 онд төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирол, төлбөр барагдуулалтад 16.0 тэрбум төгрөг олгохоор төсөвт тусгасан байна.

Дээрх нөхөн төлбөрийн гүйлгээнүүд ШШГЕГ-т бүртгэсэн шийдвэрийн дарааллын дагуу хийдэг байна. Тус сангийн хөрөнгийг олгох эрхийг асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ТЕЗ-аас эрх шилжүүлэн өгөх нь учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, хараат бус байдлыг нэмэгдүүлэхээр байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засаг, аялал жуулчлал, бүтээн байгуулалтын бодлогын нөлөөгөөр гадаад улсаас зорчиж буй жуулчин, ажилчдын тоо, эргэлттэй холбоотойгоор Гадаадын иргэн харьяатын газрын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө давж биелэх нь дахин давтагдах шинжтэй байгаа тул төсвийг үндэслэлтэй төлөвлөж, төсвийн санхүүжилтийн хамаарлыг бууруулах, татварын бус орлогын орон зайг нэмэгдүүлэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлага бий болсон байна.

Түүнчлэн хууль зүйн салбарын зарим агентлагууд улсын төсвийн хөрөнгө оруулалтаас бусад санхүүгийн түрээс /лизинг/-ийн гэрээ байгуулан хөрөнгө бэлтгэх, гэрээ, хэлцлийн үндсэн дээр материаллаг нөлөө бүхий төлбөрийн үүрэг хүлээн өр төлбөр үүсгэж байгаа зэрэг нь нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгэж буй боловч дараагийн төсвийн жилүүдийн суурь зарлагыг нэмэгдүүлж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зарчим алдагдах, төсвийн хүрээний мэдэгдэл, төлөвлөлтийн ач холбогдлыг сулруулах шалтгаан болж байна.

Мөн дээрх санхүүгийн хэрэгслийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүгийн тайланд тусгахдаа гэрээ дуусгавар болох үе хүртэл хэрхэн элэгдлийн зардлыг хасагдуулаг хийх, өмчлөлд шилжих хөрөнгийн өртгийн хүлээн зөвшөөрөлт зэрэг "УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө", "УСНББОУС-13 Түрээс"-тэй холбоотой салбарын хэмжээнд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлого боловсруулаагүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болох Төрийн үнэт цаас хэвлэл төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой хуулийн этгээдийн борлуулалт жил бүр буурах төлөвтэй, үйлдвэрлэх, борлуулах бүтээгдэхүүний төрөл хязгаарлагдмал байгаа нь урт хугацаанд зах зээлд оршин тогтнож чадахгүй байх эрсдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд Төрийн үнэт цаас хэвлэл ТӨОХХК-ийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратегийн

бодлогын баримт бичгийн хэлбэрээр өгөгдсөн зөвлөмж, чиглэлийн дагуу Монгол Улсын иргэдийн хилээр зорчих нууцлал бүхий паспортын үйлдвэрлэлд шаардлагатай худалдан авалт, үйлдвэрлэлийн тоо хэмжээтэй холбоотой мэдээллүүд, аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй дээрх салбарын төрийн нууцад хамаарах төрийн цэргийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, хуульд заасан бусад дэлгэрэнгүй мэдээллийг тайлан хэрэглэгчдэд толилуулаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

С.МАГНАЙСҮРЭН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/мянган төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **669,883,797.0** | **740,406,902.3** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 248,053,810.5 | 297,208,595.6 |
| 33 | АВЛАГА | 88,142,160.2 | 103,256,162.7 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 47,332,369.9 | 17,653,926.2 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 242,530,760.6 | 275,053,863.8 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 236,340.3 | 699,269.3 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 43,588,355.4 | 46,535,084.7 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,258,559,808.0** | **1,433,909,928.8** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,258,559,808.0 | 1,433,909,928.8 |
| 39200 | Биет хөрөнгө | 898,848,860.1 | 1,062,112,545.3 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 355,647,170.3 | 367,348,565.7 |
| 39400 | Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 4,063,777.7 | 4,448,817.8 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **1,928,443,605.0** | **2,174,316,831.1** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **297,795,349.1** | **324,172,592.9** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **297,741,386.9** | **324,172,592.9** |
| 41200 | Богино хугацаат зээлийн өглөг | 1,569,840.0 | 145,000.0 |
| 41300 | Өглөг | 206,900,067.2 | 258,048,969.0 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 89,271,479.7 | 65,978,623.9 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **53,962.2** | **-** |
| 42200 | Урт хугацаат зээл | 53,962.2 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,630,648,255.9** | **1,850,144,238.2** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,630,648,255.9 | 1,850,144,238.2 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 485,785,544.8 | 485,316,060.6 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 18,877,485.3 | 33,486,856.7 |
| 51102 | Өмч /хувийн/ /ТӨҮГ/ | 15,483,203.0 | 15,483,203.0 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 922,118,374.2 | 1,130,130,669.6 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 188,383,648.7 | 185,727,448.3 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5** | **1,928,443,605.0** | **2,174,316,831.1** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *Iмянган төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **1,642,729,707.4** | **1,867,080,499.4** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 15,885,433.9 | 17,989,560.6 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 15,885,433.9 | 17,989,560.6 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 187,803,378.8 | 1,849,090,938.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 184,477,605.9 | 148,888,007.3 |
| 122 | Тусламжийн орлого | 3,325,772.9 | 1,700,202,931.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,439,040,894.8 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,368,637,996.8** | **1,653,094,057.5** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,368,637,996.8 | 1,653,094,057.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,243,739,702.5 | 1,507,288,970.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 806,305,091.1 | 996,361,963.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 30,517,028.9 | 36,939,132.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,840,306.8 | 37,027,363.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 55,733,923.4 | 49,045,200.2 |
| 2105 | Нормативт зардал | 67,531,733.3 | 86,817,680.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 17,953,049.7 | 17,175,415.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,246,702.0 | 3,998,039.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 61,193,018.2 | 81,073,867.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 171,418,849.3 | 198,850,308.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 124,898,294.3 | 145,805,087.5 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **274,091,710.7** | **213,986,441.9** |
| **IV** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **176,376.4** | **494,673.0** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **23,271,543.9** | **7,884,020.3** |
| **VII** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)** | **(23,095,167.5)** | **(7,389,347.3)** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(мянган төгрөгөөр)*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 485,919,649.7 | 193,142,081.0 | 688,320,523.8 | 1,367,382,254.5 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (17,198,692.7) | (17,198,692.7) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 485,919,649.7 | 193,142,081.0 | 671,121,831.0 | 1,350,183,561.8 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (4,758,432.3) | - | (4,758,432.3) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 34,226,583.4 | - | - | 34,226,583.4 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 250,996,543.2 | 250,996,543.2 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 520,146,233.1 | 188,383,648.7 | 922,118,374.2 | 1,630,648,255.9 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 6,734,791.3 | (563.7) | 2,650,955.3 | 9,385,182.9 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 526,881,024.4 | 188,383,085.0 | 924,769,329.5 | 1,640,033,438.9 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (3,129,225.1) | - | (3,129,225.1) |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 7,407,741.0 | (500,394.3) | - | 6,907,346.7 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | (2,645.1) | 973,982.7 | (1,235,754.5) | (264,416.9) |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 206,597,094.6 | 206,597,094.6 |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 534,286,120.3 | 185,727,448.3 | 1,130,130,669.6 | 1,850,144,238.2 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *... /мянган төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **2,527,943,569.5** | **2,360,129,911.8** |
| **2** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **31,707,920.4** | **12,881,620.5** |
| 3 | Бусад татвар, төлбөр, хураамж | 31,707,920.4 | 12,881,620.5 |
| 4 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 31,707,920.4 | 12,881,620.5 |
| **5** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,057,854,589.7** | **2,347,248,291.2** |
| 6 | Нийтлэг татварын бус орлого | 1,057,854,589.7 | 697,663,413.4 |
| 7 | Тусламжийн орлого | - | 1,649,579,877.8 |
| 8 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | - | 5,000.0 |
| **9** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,438,381,059.4** | **-** |
| **10** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,192,102,716.0** | **2,175,587,441.4** |
| **11** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,192,102,716.0** | **2,175,587,441.4** |
| **12** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,012,874,493.2** | **1,983,973,461.9** |
| 13 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 815,310,173.9 | 1,007,768,792.9 |
| 14 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 31,355,608.0 | 38,560,458.2 |
| 15 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 30,395,739.1 | 37,491,921.7 |
| 16 | Хангамж, бараа материалын зардал | 102,427,489.6 | 64,560,440.0 |
| 17 | Нормативт зардал | 83,031,181.3 | 96,010,427.0 |
| 18 | Эд хогшил, урсгал засварын зардал | 31,285,951.7 | 43,642,018.9 |
| 19 | Томилолт, зочны зардал | 4,330,926.2 | 4,022,956.4 |
| 20 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 120,200,367.0 | 161,544,719.1 |
| 21 | Бараа үйлчилгээний бусад зардал | 794,537,056.0 | 530,371,727. |
| **22** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **179,228,222.8** | **191,613,979.4** |
| **23** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **335,840,853.4** | **184,542,470.4** |
| **24** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **14,831.7** | **41,019.4** |
| **25** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **165,481,172.9** | **135,135,059.9** |
| **26** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **165,481,172.9** | **135,135,059.9** |
| 27 | Дотоод эх үүсвэрээр | 165,481,172.9 | 135,135,059.9 |
| **28** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(165,466,341.1)** | **(135,094,040.4)** |
| 29 | Бусад эх үүсвэр | 2,846,127.9 | 2,605,828.1 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *(/төгрөгөөр/)*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **1,624,287,144,500.00** | **1,573,357,347,220.54** | **50,929,797,279.46** | **96.9** |
| 12 | Татварын бус орлого | 1,624,287,144,500.00 | 1,573,357,347,220.54 | 50,929,797,279.46 | 96.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 31,686,352,100.00 | 56,061,978,526.60 | (24,375,626,426.60) | 176.9 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 20,552,175,800.00 | 41,904,421,612.66 | (21,352,245,812.66) | 203.9 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 11,134,176,300.00 | 14,157,556,913.94 | (3,023,380,613.94) | 127.2 |
| 122 | Тусламжийн орлого | 1,592,600,792,400.00 | 1,517,295,368,693.94 | 75,305,423,706.06 | 95.3 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 1,052,495,000.00 | 1,137,734,189.37 | (85,239,189.37) | 108.1 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,591,548,297,400.00 | 1,516,157,634,504.57 | 75,390,662,895.43 | 95.3 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,603,774,515,400.00** | **1,546,807,893,811.71** | **56,966,621,588.29** | **96.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,519,654,560,000.00** | **1,452,200,843,936.22** | **67,453,716,063.78** | **95.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,396,897,809,400.00** | **1,336,431,653,451.95** | **60,466,155,948.05** | **95.7** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 982,983,443,600.00 | 960,039,484,760.95 | 22,943,958,839.05 | 97.7 |
| 210101 | Үндсэн цалин | 492,266,725,300.00 | 494,282,710,965.85 | (2,015,985,665.85) | 100.4 |
| 210102 | Нэмэгдэл | 379,621,309,100.00 | 361,284,775,650.18 | 18,336,533,449.82 | 95.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 53,962,590,800.00 | 49,944,712,947.87 | 4,017,877,852.13 | 92.6 |
| 210104 | Урамшуулал | 40,487,818,100.00 | 38,732,400,822.97 | 1,755,417,277.03 | 95.7 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,645,000,300.00 | 15,794,884,374.08 | 850,115,925.92 | 94.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 37,149,557,700.00 | 34,622,447,425.17 | 2,527,110,274.83 | 93.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,443,078,100.00 | 13,385,466,374.03 | 1,057,611,725.97 | 92.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,564,787,800.00 | 1,453,823,751.80 | 110,964,048.20 | 92.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 652,922,700.00 | 625,474,305.46 | 27,448,394.54 | 95.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 595,887,600.00 | 464,005,617.52 | 131,881,982.48 | 77.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,892,881,500.00 | 18,693,677,376.36 | 1,199,204,123.64 | 94.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 38,550,020,500.00 | 36,166,135,164.86 | 2,383,885,335.14 | 93.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,449,283,700.00 | 13,770,167,676.29 | 679,116,023.71 | 95.3 |
| 210302 | Түлш, халаалт | 18,637,219,000.00 | 17,805,695,758.95 | 831,523,241.05 | 95.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,902,412,600.00 | 2,699,713,872.79 | 202,698,727.21 | 93.0 |
| 210304 | Байрны түрээс | 2,561,105,200.00 | 1,890,557,856.83 | 670,547,343.17 | 73.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 34,206,128,300.00 | 30,867,960,818.37 | 3,338,167,481.63 | 90.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,639,658,100.00 | 3,426,474,405.23 | 1,213,183,694.77 | 73.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,739,719,100.00 | 21,795,958,985.13 | 943,760,114.87 | 95.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,084,970,400.00 | 1,729,452,686.96 | 355,517,713.04 | 82.9 |
| 210404 | Ном, хэвлэл | 79,079,500.00 | 69,138,810.00 | 9,940,690.00 | 87.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 208,794,000.00 | 147,419,425.00 | 61,374,575.00 | 70.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,453,907,200.00 | 3,699,516,506.05 | 754,390,693.95 | 83.1 |
| 2105 | Нормативт зардал | 93,880,911,600.00 | 86,193,482,142.37 | 7,687,429,457.63 | 91.8 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,032,685,800.00 | 4,038,582,451.22 | 1,994,103,348.78 | 66.9 |
| 210502 | Хоол, хүнс | 29,338,150,300.00 | 28,237,892,565.56 | 1,100,257,734.44 | 96.2 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 58,510,075,500.00 | 53,917,007,125.59 | 4,593,068,374.41 | 92.1 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,813,152,400.00 | 30,974,737,145.14 | 4,838,415,254.86 | 86.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,409,389,800.00 | 11,098,654,256.07 | 2,310,735,543.93 | 82.8 |
| 210602 | Тавилга | 88,500,000.00 | 79,990,000.00 | 8,510,000.00 | 90.4 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,168,935,400.00 | 456,538,653.00 | 712,396,747.00 | 39.1 |
| 210604 | Урсгал засвар | 21,146,327,200.00 | 19,339,554,236.07 | 1,806,772,963.93 | 91.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 4,684,562,300.00 | 3,340,564,579.60 | 1,343,997,720.40 | 71.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210701 | Гадаад албан томилолт | 936,704,900.00 | 883,329,073.80 | 53,375,826.20 | 94.3 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,591,033,400.00 | 2,369,552,647.80 | 1,221,480,752.20 | 66.0 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 156,824,000.00 | 87,682,858.00 | 69,141,142.00 | 55.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 98,973,057,500.00 | 89,703,503,389.48 | 9,269,554,110.52 | 90.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 82,332,358,300.00 | 75,687,122,357.44 | 6,645,235,942.56 | 91.9 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 42,338,600.00 | 10,720,800.00 | 31,617,800.00 | 25.3 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,399,527,000.00 | 2,866,296,864.24 | 533,230,135.76 | 84.3 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 579,590,000.00 | 470,338,925.07 | 109,251,074.93 | 81.2 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,343,700.00 | 37,746,651.00 | 37,597,049.00 | 50.1 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,776,452,600.00 | 6,227,525,202.13 | 1,548,927,397.87 | 80.1 |
| 210807 | Газрын төлбөр | 925,105,500.00 | 784,321,619.90 | 140,783,880.10 | 84.8 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 5,500,000.00 | 400,000.00 | 5,100,000.00 | 7.3 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 3,836,841,800.00 | 3,619,030,969.70 | 217,810,830.30 | 94.3 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 70,656,975,500.00 | 64,523,338,026.01 | 6,133,637,473.99 | 91.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,217,843,600.00 | 55,606,996,859.62 | 4,610,846,740.38 | 92.3 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,439,131,900.00 | 8,916,341,166.39 | 1,522,790,733.61 | 85.4 |
| 212 | ТАТААС | 5,630,000,000.00 | 5,299,980,000.00 | 330,020,000.00 | 94.1 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 5,630,000,000.00 | 5,299,980,000.00 | 330,020,000.00 | 94.1 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 5,630,000,000.00 | 5,299,980,000.00 | 330,020,000.00 | 94.1 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117,126,750,600.00** | **110,469,210,484.27** | **6,657,540,115.73** | **94.3** |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 399,248,200.00 | 389,589,945.35 | 9,658,254.65 | 97.6 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 399,248,200.00 | 389,589,945.35 | 9,658,254.65 | 97.6 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 116,727,502,400.00 | 110,079,620,538.92 | 6,647,881,861.08 | 94.3 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,566,794,500.00 | 2,403,890,596.00 | 162,903,904.00 | 93.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5,625,061,000.00 | 4,163,730,900.00 | 1,461,330,100.00 | 74.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 78,872,558,800.00 | 76,322,880,539.04 | 2,549,678,260.96 | 96.8 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 24,628,214,600.00 | 23,830,286,916.19 | 797,927,683.81 | 96.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,034,873,500.00 | 3,358,831,587.69 | 1,676,041,912.31 | 66.7 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **104,720,700,000.00** | **94,607,049,875.49** | **10,113,650,124.51** | **90.3** |
| 220001 | Барилга байгууламж | 14,910,000,000.00 | 12,710,245,218.00 | 2,199,754,782.00 | 85.2 |
| 221001 | Их засвар | 4,190,800,000.00 | 4,190,708,107.00 | 91,893.00 | 100.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 85,619,900,000.00 | 77,706,096,550.49 | 7,913,803,449.51 | 90.8 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **-20,600,744,600.00** | **-** | **(20,600,744,600.00)** | **-** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | -20,600,744,600.00 | - | (20,600,744,600.00) | - |
| **8** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **20,512,629,100.00** | **26,549,453,408.83** | **(6,036,824,308.83)** | **129.4** |
| **9** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-20,512,629,100.00** | **(26,549,453,408.83)** | **6,036,824,308.83** | **129.4** |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | -20,512,629,100.00 | (26,549,453,408.83) | 6,036,824,308.83 | 129.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 48,849,622,658.47 | (48,849,622,658.47) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 67,250,469,218.82 | (67,250,469,218.82) | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **56,835** | **55,640** | **1,195** | **97.9** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **208** | **208** | **-** | **100.0** |
| 610001 | Төсвийн байгууллага | 208 | 208 | - | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **27,452** | **27,049** | **403** | **98.5** |
| 620001 | Удирдах ажилтан | 488 | 491 | (3) | 100.6 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22,833 | 22,459 | 374 | 98.4 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2,334 | 2,313 | 21 | 99.1 |
| 620004 | Гэрээт ажилтан | 1,797 | 1,786 | 11 | 99.4 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **27,452** | **27,049** | **403** | **98.5** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 1,230 | 1,212 | 18 | 98.5 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 24,070 | 23,698 | 372 | 98.5 |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | 21 | 21 | - | 100.0 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 39 | 36 | 3 | 92.3 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | 1 | 1 | - | 100.0 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 66 | 66 | - | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 1,618 | 1,643 | (25) | 101.5 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 1 | 3 | (2) | 300.0 |
| 650012 | Шүүгч, прокурор | 83 | 73 | 10 | 88.0 |
| 650014 | Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ) | 323 | 296 | 27 | 91.6 |
| **66** | **НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ** | **1,723** | **1,334** | **389** | **77.4** |
| 660001 | Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 616 | 584 | 32 | 94.8 |
| 660003 | Эрүүл мэндийн тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 4 | - | 4 | - |
| 660004 | Цэргийн албан хаагчийн тэтгэврийн тухай хуулиар тэтгэвэрт гарагч | 1,088 | 735 | 353 | 67.6 |
| 660005 | Хөдөлмөрийн тухай хуулиар тэтгэвэрт гарагч /Бусад/ | 15 | 15 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **108,289,550.04** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **108,289,550.04** |
| **122** | **Тусламжийн орлого** | **108,289,550.04** |
| **1221** | **Хандив тусламж /дотоод/** | **108,289,550.04** |
| **12213** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **108,289,550.04** |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 499,107.12 |
| 350013 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,408,534.65 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 14,806,699.35 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 80,548,500.85 |
| 350017 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 26,708.06 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **104,809,237.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **96,931,350.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **94,015,624.14** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **24,786,191.67** |
| 210101 | Үндсэн цалин | 9,463,449.32 |
| 210102 | Нэмэгдэл | 2,972,294.53 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 116,052.49 |
| 210104 | Урамшуулал | 9,402,984.13 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,831,411.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,400,330.81** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 328,978.07 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 36,895.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 21,792.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,235.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 998,429.16 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **456,997.55** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 136,600.64 |
| 210302 | Түлш, халаалт | 162,535.09 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,193.18 |
| 210304 | Байрны түрээс | 147,668.64 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,809,402.56** |
| 210401 | Бичиг хэрэг | 187,509.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,094,790.29 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 116,859.79 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,078.55 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,685.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,402,479.53 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,581,237.27** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 68,388.27 |
| 210502 | Хоол, хүнс | 1,992,927.26 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,519,921.74 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,329,427.59** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,281,082.86 |
| 210602 | Тавилга | 115,911.90 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 190,492.94 |
| 210604 | Урсгал засвар | 9,741,939.89 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **564,073.90** |
| 210701 | Гадаад албан томилолт | 156,307.82 |
| 210702 | Дотоод албан томилолт | 384,680.03 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 23,086.05 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **15,505,095.86** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,391,976.34 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,835.62 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 4,592.84 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 187.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 103,732.82 |

| | | |
|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 1,651.24 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,120.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **18,582,866.93** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,753,993.45 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 828,873.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,915,726.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,915,726.10** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 308,354.88 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,607,371.22 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,877,887.69** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **7,877,887.69** |
| 220001 | Барилга байгууламж | 5,481,209.09 |
| 221001 | Их засвар | 70,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 2,326,678.60 |
| **4** | **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **3,480,312.11** |
| **5** | **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **(3,480,312.11)** |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (3,480,312.11) |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудал

Засгийн газрын 2020 оны 95 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн яамны стратеги, зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг баталсан бөгөөд тус яамны эрхэм зорилгыг "Үндэсний эрхэмлэн дээдлэх зүйлсийг хадгалан хамгаалах, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэн, хууль зүйн салбарын бодлого, төлөвлөлтийн үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлнэ" гэж тодорхойлсон байна.

### 3.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний эрхлэх асуудлын хүрээний хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хууль болон Хууль тогтоомжийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын хилийн тухай, Цагдаагийн албаны тухай, Шүүх шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Архивын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх дараах хууль тогтоомж, бодлого, чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болгосонд тооцох тухай;
- Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотод аудитын газар 2025 онд нийт 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.5 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Тайлант онд Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дараах хяналт, шалгалт, аудитыг гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/82, А/29 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаа;
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын "Ажлын хэсэг байгуулж, удирдамж батлах тухай" 2025 оны А/11 дүгээр тушаалаар Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа;
- Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/88 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу тус яамны албан хаагчдын ажлыг цаг ашиглалт, ажлын бүтээмж, үр дүн, гүйцэтгэл;
- Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд "Хуулийн байгууллагын ажилтан, албан хаагчдын цогцолбор хороолол 101, 102 дугаар барилга"-ын ажилтай холбоотой үүссэн нөхцөл байдал.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хууль зүйн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх зорилгоор ХЗДХС-ын 2024 оны А/64 дүгээр тушаалаар Ажлын хэсэг байгуулж, “Хууль зүй, дотоод хэргийн салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг сайдын А/180 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *ХЗДХЯ (ТШЗ): Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэлээр тавих дотоод хяналт, тайлан бүртгэл хөтөлдөг Юникс программ хөгжүүлэлт хийж, санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журамд нийцүүлэн сайжруулалт хийгээгүй.*

Салбарын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 245,873.2 сая төгрөгөөр буюу 12.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 248,053.8 | 297,208.6 | 49,154.8 |
| Авлага | 88,142.2 | 103,256.2 | 15,114.0 |
| Урьдчилгаа | 47,332.4 | 17,653.9 | (29,678.4) |
| Бараа материал | 242,530.8 | 275,053.9 | 32,523.1 |
| Нөөцийн бараа | 236.3 | 699.3 | 462.9 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 43,588.4 | 46,535.1 | 2,946.7 |
| Үндсэн хөрөнгө | 1,258,559.8 | 1,433,909.9 | 175,350.1 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **1,928,443.6** | **2,174,316.8** | **245,873.2** |
| Нийт өр төлбөрийн дүн | 297,795.3 | 324,172.6 | 26,377.2 |
| Засгийн газрын хувь оролцоо | 1,630,648.3 | 1,850,144.2 | 219,496.0 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,928,443.6** | **2,174,316.8** | **245,873.2** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, Засгийн газрын хувь оролцоо данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 297,208.6 сая төгрөг болж, өмнөх оноос 49,154.8 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Кассад байгаа бэлэн мөнгө** | **23.5** | **16.5** | **(7.0)** |

| | | | |
|---|---|---|---|
| **Банканд байгаа бэлэн мөнгө** | **248,030.3** | **297,177.2** | **49,146.9** |
| **Төгрөг** | **237,912.9** | **286,042.2** | **48,129.3** |
| Төрийн сангийн харилцах | 73,660.2 | 94,848.0 | 21,187.8 |
| Арилжааны банк дахь харилцах | 164,252.7 | 191,194.2 | 26,941.5 |
| **Гадаад валют** | **10,117.4** | **11,135.0** | **1,017.6** |
| Төрийн сангийн харилцах | 9,027.4 | 10,180.3 | 1,153.0 |
| Арилжааны банк дахь харилцах | 1,090.0 | 954.7 | (135.4) |
| **Замд яваа мөнгөн хөрөнгө** | **-** | **14.9** | **14.9** |
| **Дүн** | **248,053.8** | **297,208.6** | **49,154.8** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Нийт мөнгөн хөрөнгийн 99.9 хувь буюу 297,177.2 сая төгрөг нь банканд байгаа мөнгө эзэлж байна. Үүнээс төрийн сангийн харилцах дансны 105,028.4 сая төгрөг, арилжааны банкны харилцах дансны 192,148.8 сая төгрөгийн үлдэгдэл байна. Төрийн сангийн харилцах дансанд дараах байгууллагын эх үүсвэрүүд бүртгэлтэй байна. Үүнд:

- ШШГЕГ-ын ГХХНТОС 44,204.0 сая төгрөг, АСТУСҮАДС 23,046.1 сая төгрөг, ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хөрөнгө оруулалтын барьцаа 21,766.8 сая төгрөг, ШШГЕГ-ын ТӨААТҮГ-ын үйл ажиллагаанаас бий болсон эх үүсвэр 3,366.4 сая төгрөг, БТБГ-ын 1,336.3 сая төгрөг, ШШГЕГ-ын харьяа нээлттэй, хаалттай 40 хорих ангийн ялтны нэрийн дансанд 601.8 сая төгрөг, ЦЕГ, ШШГЕГ-ын техник хяналтын 496.8 сая төгрөг, ТТАХНЭ-ийн харилцах 26.1 сая төгрөг, ДХИС-ын оюутны зээл, эрсдэлийн санд 3.7 сая төгрөг, нийт 94,848.0 сая төгрөг.

Дотоодын 6 арилжааны банк дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн 98.7 хувь буюу 189,734.4 сая төгрөг нь ШШГЕГ-ын харьяа аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газруудын шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төлбөр байна.

Үүнээс Медипас ХХК, Медипас нийгэмлэгийн нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар Сингапурын Олон Улсын Арбитрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар шийдвэрээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 29,285,938.58 ам.доллар буюу 101,874.2 сая төгрөгийг төлүүлэх шийдвэр гарснаас шалтгаалан Орхон аймаг дахь ШШГГ-ын 437 дугаар нээлттэй хорих ангийн шийдвэр гүйцэтгэлийн дансанд байршуулсан төлбөрийн үлдэгдэл байна.

Төрийн сан дахь гадаад валютын харилцах дансны үлдэгдэлд Эрүүгийн цагдаагийн албаны эрүүгийн хэргээс хураан авсан 10,180.3 сая төгрөгийн барьцаа хөрөнгө байршиж байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *ЦЕГ-ын харьяа байгууллагууд татвар, хураамжийг илүү, дутуу тооцож төлсөн 490.3 сая төгрөг, зардлыг хэтрүүлсэн, үр ашиггүй зардал гаргасан, эдийн засгийн ангилал зөрчсөн 410.0 сая төгрөг;*
- *УБЕГ-ын харьяа байгууллагууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй зарцуулсан 166.2 сая төгрөг,анхан шатны баримтгүй 98.6 сая төгрөг, эдийн засгийн ангилал хэтрүүлэн зарцуулсан 49.6 сая төгрөг, урамшуулал олгосон 43.4 сая төгрөг, эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан 1.3 сая төгрөг;*
- *ГИХГ-ын харьяа байгууллагууд улсын тэмдэгтийн хураамж дутуу төлсөн 156.5 сая төгрөг, 10.3 сая төгрөгийг арга хэмжээний дагуу зарцуулаагүй, урамшуулал давхардуулан олгосон 0.4 сая төгрөг;*
- *ШШГЕГ-ын харьяа байгууллагууд ажилтнуудад үндэслэн чиг үүрэгт заагдаагүй ажилд 75.3 сая төгрөг, сахилгын шийтгэл оногдуулсан албан хаагчид урамшуулал олгосон, цалингийн зардлаас, илүү, дутуу тооцож олгосон зэрэг нийт 36.3 сая төгрөг, хоол, томилолтын зардлыг хуулийн этгээдэд шилжүүлэн зарцуулсан 15.9 сая төгрөг;*
- *ШШЕГ-ын харьяа байгууллагууд урамшуулал давхардуулан олгосон 37.6 сая төгрөг, спортын тэмцээн зохион байгуулсан 7.1 сая төгрөг, эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан 5.1 сая төгрөг; зах зээлийн ханшнаас өндөр үнээр хөрөнгө бэлтгэсэн 2.2 сая төгрөг.*

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 103,256.2 сая төгрөг болж, өмнөх оноос 15,114.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 226.5 | 396.1 | 169.6 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 245.9 | 188.0 | (57.9) |

| | | | |
|---|---|---|---|
| Татаас, санхүүжилтийн авлага | 2,001.2 | 12,941.9 | 10,940.7 |
| Дансны авлага /ТӨҮГ/ | 3,487.6 | 6,497.6 | 3,010.0 |
| Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 826.5 | 364.9 | (461.6) |
| **Бусад авлага** | **36,126.2** | **37,713.1** | 1,587.0 |
| Байгууллагаас авах авлага | 34,367.7 | 35,745.5 | 1,377.8 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 1,758.4 | 1,967.6 | 209.2 |
| **Зээлийн авлага** | **45,228.2** | **45,154.4** | (73.8) |
| **Дүн** | **88,142.2** | **103,256.2** | **15,114.0** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Тайлант онд ажиллагчидтай холбогдсон авлага 169.6 сая төгрөгөөр өссөн нь ЦЕГ-ын ажилтнуудын үр дүнгийн урамшуулал 241.3 сая төгрөгөөс тооцсон татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийг авлагад тусгаснаас шалтгаалсан байна.

Төлбөртэй үйлчилгээний авлага 188.0 сая төгрөг болж, 57.9 сая төгрөгөөр буурсан нь ТЗЦГ-ын гэрээний дагуу авах 66.0 сая төгрөгийн авлага барагдаж, ХЗҮХ-ийн 5.1 сая төгрөгийн хууль, эрх зүйн сэтгүүл, ном борлуулсны авлагыг нэмж бүртгэснээс шалтгаалсан байна.

Татаас, санхүүжилтийн авлага 12,941.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь хууль зүйн салбарын харьяа 62 байгууллагын давсан орлогын 5,643.2 сая төгрөг, 15 байгууллагын нэмэлт төсвийн 3,241.7 сая төгрөг, 100 байгууллагын ахмадын сангийн 3,072.1 сая төгрөг, 13 байгууллагын урсгал төсвийн үлдэгдлийн 893.8 сая төгрөг, ХЗДХЯ-ны хөрөнгө оруулалтын санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийн 91.1 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Дансны авлага 6,497.6 сая төгрөг болж, 3,010.0 сая төгрөгөөр өссөн нь ТҮЦХ ТӨОХХК-ийн УБЕГ, ГХЯ-аас авах 72.0 сая төгрөг, гадаад паспорт борлуулалтын авлага 3,430.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Байгууллагаас авах авлага 35,745.5 сая төгрөг болж, 1,377.8 сая төгрөгөөр өссөн нь Бүгд найрамдах Унгар улсын Унгарын мөнгөн тэмдэгт хэвлэл хувьцаат компаниас авах 3,760.0 сая төгрөгийн авлагыг нэмж бүртгэснээс шалтгаалсан байна. Зарим томоохон үлдэгдэлтэй авлагыг тодруулбал:

- ШШГЕГ: Банкны төлбөр барагдуулахтай холбоотой ХОТШ банк ХХК-аас авах 9,258.6 сая төгрөг, Ард банк ХХК-аас авах 7,662.5 сая төгрөг, хөдөө орон нутгийн зээлийн авлага 4,085.2 сая төгрөг, Сэргээн босголт банк ХХК-аас авах 2,960.6 сая төгрөг, Монгол даатгал банк ХХК-аас авах 2,441.0 сая төгрөг, Хоршоо банк ХХК-аас авах 700.7 сая төгрөг, Төв Ази банк ХХК-аас авах 639.9 сая төгрөг, өрхийн амьжиргааны төслийг дэмжих зээлийн 362.8 сая төгрөг, нийт 29,085.3 сая төгрөг.

Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон авлагын 45,154.4 сая төгрөгийн үлдэгдэлд 18 дампуурсан хадгаламж зээлийн хоршоодоос авах авлагууд бүртгэлтэй байна.

**Аудитын илрүүлэлт:**
- *ЦЕГ-ын харьяа байгууллагууд татаас санхүүжилтийн авлага үүсгэсэн 1,947.9 сая төгрөг, санхүүгийн тайланд авлага нэмэгдүүлэн бүртгэсэн 920.8 сая төгрөг, татвар, шимтгэлийн илүү төлөлт хийж авлага үүсгэсэн 34.8 сая төгрөг;*
- *ГИХГ-ын харьяа байгууллагууд үйл ажиллагааны орлогын биелэлтээс бий болсон 2,010.4 сая төгрөгийн авлагыг тайланд тусгасан;*
- *ШШГЕГ-ын харьяа байгууллагууд борлуулалтаас үүссэн 395.9 сая төгрөгийн авлага барагдуулаагүй, гэрээний дагуу 9.0 сая төгрөгийн төлбөр төлөгдөөгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй 7.3 сая төгрөг, авлагаар тайлагнаагүй 4.0 сая төгрөг.*

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 17,653.9 сая төгрөг болж, өмнөх оноос 29,678.4 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл* /сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар | 70.7 | - | (70.7) |
| Урьдчилж гарсан зардал | 12,821.6 | 11,405.9 | (1,415.7) |

| | | | |
|---|---|---|---|
| Урьдчилгаа тооцоо | 34,440.1 | 6,248.0 | (28,192.0) |
| **Дүн** | **47,332.4** | **17,653.9** | **(29,678.4)** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Урьдчилгаа дансны үлдэгдэл 25,695.2 сая төгрөгөөр буурсан нь ХХЕГ-ын үндсэн хөрөнгө бэлтгэх зорилгоор хийсэн гэрээний санхүүжилтийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Түүнчлэн Санхүү ар талын албаны тэтгэвэр тэтгэмжийн 18 сарын урьдчилгааны 7,496.3 сая төгрөг, нууцын байгууллагын 3,322.3 сая төгрөг, он дамжин хэрэгжиж байгаа алба хаагчдын хувцас, хэрэгслийн гэрээний дагуу шилжүүлсэн 2,507.0 сая төгрөг, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 4,989.2 сая төгрөгөөр буурсан зэргээс нөлөөлжээ.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 275,053 сая төгрөг болж, өмнөх оноос 32,523.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Түүхий эд материал** | **53,117.1** | **73,381.0** | **20,263.9** |
| Тусгай зориулалттай материал | 48,881.0 | 69,855.8 | 20,974.8 |
| Эм боох материал | 4,236.1 | 3,525.3 | (710.9) |
| **Дуусаагүй үйлдвэрлэл** | **28,721.0** | **3,448.1** | **(25,272.9)** |
| **Бэлэн бүтээгдэхүүн** | **41,674.6** | **57,329.3** | **15,654.7** |
| **Хангамжийн материал** | **101,580.9** | **114,889.6** | **13,308.8** |
| Бичиг хэргийн материал | 2,378.7 | 4,033.8 | 1,655.1 |
| Аж ахуйн материал | 14,363.8 | 18,238.8 | 3,875.0 |
| Сэлбэг хэрэгсэл | 4,895.9 | 4,589.0 | (306.9) |
| Түлш, шатах тослох материал | 4,553.0 | 5,741.1 | 1,188.1 |
| Барилгын засварын материал | 4,798.6 | 5,256.9 | 458.3 |
| Хүнсний материал | 7,061.6 | 8,163.5 | 1,101.9 |
| Бусад хангамжийн материал | 63,529.3 | 68,866.5 | 5,337.2 |
| **Биологийн хөрөнгө** | **707.5** | **8,584.7** | **7,877.3** |
| **Мал амьтад** | **16,729.7** | **17,421.0** | **691.3** |
| **Дүн** | **242,530.8** | **275,053.9** | **32,523.1** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Тайлант онд худалдан авсан 467,088.2 сая төгрөг, хандив, тусламжаар үнэ төлбөргүй авсан 5,893.4 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 84,631.2 сая төгрөг, бусад тооцоогоор 104,413.7 сая төгрөг, нийт 622,026.5 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 326,528.8 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 233,850.6 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 224.4 сая төгрөг, бусад 68,436.6 сая төгрөг, нийт 629,040.5 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл 3,448.1 сая төгрөг болсон бөгөөд тус дансанд ХХЕГ, ШШГЕГ-ын харьяа байгууллагууд 58,619.8 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд оруулж, 65,908.4 сая төгрөгийн хөрөнгийг борлуулснаас шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 32,523.1 сая төгрөгөөр өсөхөд ТҮЦХ ТӨОХХК-ийн гадаад паспортын бэлдэц худалдан авалт голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- *УБЕГ-ын харьяа байгууллагууд өмнө онуудад 1,351.1 сая төгрөгийн гологдол үүсгэсэн; чанаргүй түүхий эд худалдан авснаас 78.2 сая төгрөгийн хорогдол үүсгэсэн, гэрээний гүйцэтгэл үнэлээгүй 75.8 сая төгрөг, бүртгэлээс зөрүүтэй 2.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан;*
- *ЦЕГ-ын харьяа байгууллагууд шатахууны нөөц үүсгэсэн 41.5 сая төгрөг, ангилал зөрүүлэн бүртгэсэн 14.1 сая төгрөг, ашиглагдахгүй хөрөнгө 8.0 сая төгрөг;*
- *ШШГЕГ-ын харьяа байгууллагууд дуусаагүй үйлдвэрлэл дансанд 46.4 сая төгрөгийг тайлагнасан боловч бараа материалын дэлгэрэнгүй журналд бүртгээгүй, өртгийн тайлан тооцоолол байхгүй, бараа материалын дансанд бүртгэлтэй 2,868.5 кг ямааны мах, 382.4 кг цагаан будаа биетээр байхгүй, ангийн махны зоорийг, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад үнэ төлбөргүй ашиглуулсан.*

### 3.4.5 Нөөцийн бараа

Нөөцийн бараа дансны эцсийн үлдэгдэл 699.2 сая төгрөг болж, 462.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 6. Нөөцийн барааны үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бусад нөөц | 236.3 | 699.2 | 462.9 |
| **Дүн** | **236.3** | **699.2** | **462.9** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Бусад нөөцийн бараа дансны үлдэгдэлд Шүүх шинжилгээний ерөнхий газрын аппаратын 699.2 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

### 3.4.6 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 46,535.1 сая төгрөг болж, өмнөх оноос 2,946.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7. Бусад эргэлтийн хөрөнгийн үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад | 42,308.4 | 45,540.1 | 3,231.7 |
| БЗЭБуй эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 1,280.0 | 994.9 | (285.0) |
| **Дүн** | **43,588.4** | **46,535.1** | **2,946.7** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилгын ажлын гүйцэтгэлийг хуримтлуулж бүртгэснээс бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 2,946.7 сая төгрөгөөр нэмэгдсэн тус дансанд дараах байгууллагуудын бусад эргэлтийн хөрөнгүүд бүртгэлтэй байна. Үүнд:

- ЦЕГ: Хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй дуусаагүй 23,264.3 сая төгрөгийн 8 барилга /Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хэсгийн байр, Архангай, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий аймгийн цагдаагийн газар/, их засварын ажил 2,057.8 сая төгрөг 3 барилгын /Хангалт үйлчилгээний төв, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Нарстай дах хээрийн сургалтын байр, Оч зуслангийн байр, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 5 барилгын зургийн үнэ 38.9 сая төгрөг;
- ХХЕГ: Хөвсгөл, Цагаан-Уул сум Хилийн цэргийн ангийн барилга, Хилийн цэргийн 0287 дугаар ангийн Штабын барилга, Хилийн цэргийн 0277 дугаар ангийн барилга байгууламжийн шинэчлэл, Улсын хил хамгаалалтын зориулалтын инженерийн байгууламжийн шинэчлэлтийн ажлын нийт 18,027.0 сая төгрөг;
- ШШГЕГ: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй “Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага”-ын сургуулийн барилга 1,854.4 сая төгрөг, Хэнтий аймгийн цагдан хорих байрны барилга 117.6 сая төгрөг;
- ШШЕГ: Сэлэнгэ аймгийн ШШГ-ын лабораторийн барилгын 180.0 сая төгрөг.

### 3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,433,909.9 сая төгрөг болж, өмнөх оноос 175,350.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **898,848.9** | **1,062,112.5** | **163,263.7** |
| Барилга, байгууламж, орон сууц | 624,550.7 | 694,653.5 | 70,102.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (107,339.2) | (126,878.5) | (19,539.3) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 182,536.7 | 263,385.0 | 80,848.2 |
| Хуримтлагдсан элэгдэл | (53,482.6) | (70,625.0) | (17,142.4) |
| Машин тоног төхөөрөмж(компьютер) | 301,940.3 | 357,285.1 | 55,344.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | (112,845.5) | (128,057.6) | (15,212.1) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,994.8 | 35,375.7 | 1,381.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | (13,841.8) | (14,171.6) | (329.8) |
| Зам, гүүрийн байгууламж | 160.8 | 142.2 | (18.6) |

| | | | |
|---|---|---|---|
| Хуримтлагдсан элэгдэл | (41.6) | (23.5) | 18.1 |
| Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 24,057.8 | 30,088.4 | 6,030.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | (3,654.1) | (4,107.0) | (452.9) |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 131.4 | 131.4 | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 20,906.2 | 25,470.3 | 4,564.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | (7,023.6) | (7,065.5) | (41.9) |
| Дуусаагүй барилга, байгууламж | 7,555.7 | 5,196.5 | (2,359.2) |
| Ном | 1,243.1 | 1,313.2 | 70.2 |
| **Биет бус хөрөнгө** | **355,647.2** | **367,348.6** | **11,701.4** |
| Програм хангамж | 40,308.3 | 48,987.0 | 8,678.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (12,294.6) | (17,129.2) | (4,834.6) |
| Бусад биет бус хөрөнгө | 328,097.7 | 336,068.3 | 7,970.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | (464.3) | (577.6) | (113.4) |
| **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | **4,063.8** | **4,448.8** | **385.0** |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + бусад | 4,063.8 | 4,448.8 | 385.0 |
| **Дүн** | **1,258,559.8** | **1,433,909.9** | **175,350.1** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 30,479.1 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 50,584.6 сая төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 256,259.3 сая төгрөг, бусад 77,096.0 сая төгрөг, нийт 414,419.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр акталсан 30,203.0 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 77,794.7 сая төгрөг, бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн 19,333.8 сая төгрөг, худалдсан 237.8 сая төгрөг, бусад 52,008.7 сая төгрөг, дахин үнэлгээний хорогдол 1,842.7 сая төгрөг, нийт 181,420.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан байна. Мөн тайлант онд байгуулсан элэгдлийн дүн 147,370.6 төгрөг болон балансаас баланст шилжүүлэн авсан, акталсан хөрөнгийг хассан элэгдлийн зөрүү 5,907.4 сая төгрөг нь үндсэн хөрөнгийн бууралтад нөлөөлжээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 77 байгууллагад барилга, байгууламжийн хөдөлгөөн хийгдсэн. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 ширхэг, олон улсын дэмжлэгээр 10 ширхэг зөөврийн сууц, аймаг, нийслэлийн ЗД-ын захирамж, орон нутгийн санхүүжилтээр 7 ширхэг барилга байгууламж бүртгэсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

- *ШШГЕГ-ын харьяа байгууллагуудуп үйл ажиллагаанд ашиглагдаж буй 7,980.6 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 209 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, түүнд хяналт тавих үйл ажиллагааны нэгдсэн тогтолцоо бий болоогүй;*
- *ЦЕГ-ын харьяа байгууллагууд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 37.5 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй;*
- *УБЕГ-ын харьяа байгууллагууд дахин үнэлүүлж бүртгэлд тусгаагүй хөрөнгө 172.8 сая төгрөг, төлөвлөгөөгүй 36.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 13.5 сая төгрөгийн 3000 мкв газрыг данс бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийн бүртгэлд 572 мкв, газар эзэмших гэрчилгээ болон цахим санд 1762 мкв буюу 1190 мкв аар зөрүүтэй.*

### 3.4.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 324,172.6 сая төгрөг болж, өмнөх оноос 26,431.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл* */ сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Богино хугацаат зээлийн өглөг** | **1,569.8** | **145.0** | **(1,424.8)** |
| Өглөг | **206,900.1** | **258,049.0** | **51,148.9** |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 295.8 | 533.4 | 237.7 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,775.2 | 7,342.5 | 4,567.3 |
| Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | 9,103.0 | 15,351.6 | 6,248.6 |
| **Бусад өглөг** | **194,726.1** | **234,821.5** | **40,095.3** |
| Байгууллагад төлөх өглөг | 164,067.1 | 200,896.5 | 36,829.4 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 27,162.2 | 27,800.0 | 637.8 |

| | | | |
|---|---|---|---|
| Татварын өглөг /ТӨҮГ/ | 766.1 | 3,289.6 | 2,523.5 |
| НДШ-ийн өглөг /ТӨҮГ/ | 0.0 | 1.5 | 1.5 |
| Дансны өглөг /ТӨҮГ/ | 2,730.8 | 2,833.9 | 103.1 |
| **Урьдчилж орсон орлого** | **89,271.5** | **65,978.6** | **(23,292.9)** |
| Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | 28,923.7 | 29,081.5 | 157.8 |
| Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого | 396.5 | - | (396.5) |
| Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого | 10,414.4 | 14,113.7 | 3,699.3 |
| Бусад урьдчилж орсон орлого | 49,536.8 | 22,783.4 | (26,753.4) |
| **Дүн** | **297,741.4** | **324,172.6** | **26,431.2** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Нийт өр төлбөр дансны үлдэгдэл 324,172.6 сая төгрөг болж, өмнөх оноос 26,431.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд байгууллагад төлөх өглөг 36,829.4 сая төгрөг, хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг 6,248.6 сая төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 4,567.3 сая төгрөг, барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого 3,699.3 сая төгрөг, татварын өглөг /ТӨҮГ/ 2,523.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Үүнд:

- ЦЕГ: Тээврийн цагдаагийн албаны худалдан авах ажиллагааны 736.0 сая төгрөг, Завхан, Го,вь-Алтай, Хэнтий аймгийн тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн тэтгэмж, 30 сарын урамшууллыг татан төвлөрүүлснээс алба хаагчдад өгөх 594.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын барьцаа 446.8 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн;
- УБЕГ: ТӨХЭ-ээс харилцагч байгууллагуудад өгөх 6,581.1 сая төгрөг, агентлагаас ТҮЦХ ТӨОХХК-д өгөх гадаад паспортын бэлдэц болон бичилт хийх 3,358.6 сая төгрөг, Смарт карт ХХК-д өгөх иргэний үнэмлэхийн бэлдцийн төлбөр 1,613.5 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн;
- ШШЕГ: Шүүх шинжилгээний ерөнхий газрын тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагаанаас шалтгаалсан 3,227.3 сая төгрөгийн өглөг нэмэгдсэн;
- ШШГЕГ: Аймаг, нийслэл, орон нутгийн шийдвэр гүйцэтгэх 33 байгууллагын 27,008.4 сая төгрөгийн төлбөр авагчид өгөх шийдвэр гүйцэтгэлийн төлбөрийн өглөг нэмэгдсэн.

Сингапурын Олон Улсын Арбитрын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар шийдвэрээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 101,874.2 сая төгрөгийг төлүүлэх шийдвэр гарснаас шалтгаалан Орхон аймаг дахь ШШГГ-ын 437 дугаар нээлттэй хорих ангийн шийдвэр гүйцэтгэлийн арилжааны дансанд байршуулсан боловч прокурорын гаргасан шийдвэрийн дагуу түр хугацаанд нэхэмжлэгчид төлбөрийг шилжүүлэх асуудлыг зогсоосноос дээрх хөрөнгө байгууллагад төлөх өглөг дансны үлдэгдлийн 50 хувийг эзэлж байна.

Төрд буцаан төвлөрүүлэх дампуурсан 8 банк, 26 ХЗХ-ны улсад төлөх өглөг 49,387.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй;

Аудитын илрүүлэлт:

- *ШШЕГ-ын харьяа байгууллагууд 27 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, жилийн эцэст нийт 1,805.9 сая төгрөгийн төсвийн жилд төлөвлөгдөөгүй өр төлбөр үүсгэж, 2026 оны төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлэх шийдвэр гаргаж, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулах эрсдэлийг бий болгосон;*
- *УБЕГ-ын харьяа байгууллагууд харилцагч байгууллагуудтай хийсэн 429.2 сая төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, 5.0 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;*
- *ЦЕГ-ын харьяа байгууллагууд тайлант онд бараа үйлчилгээний зардлын 33.0 сая төгрөг, шуудан холбооны 30.6 сая төгрөг, албан томилолтын 2.3 сая төгрөг, байгууллагад төлөх 748.0 сая төгрөг, хувь хүнд өгөх 1.7 сая төгрөг, нийт 782.8 сая төгрөгийн өр төлбөр үүссэн;*

### 3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,801,174.2 сая төгрөг болж, өмнөх оноос 219,496.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо* */сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 485,785.5 | 499,925.4 | 14,139.8 |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 18,877.5 | 18,877.5 | - |
| Өмч /хувийн/ /ТӨҮГ/ | 15,483.2 | 15,483.2 | - |

| | | | |
|---|---|---|---|
| Хуримтлагдсан үр дүн | 922,118.4 | 1,130,130.7 | 208,012.3 |
| Өмнөх үеийн үр дүн | 671,121.8 | 923,533.6 | 252,411.7 |
| Тайлант үеийн үр дүн | 250,996.5 | 206,597.1 | (44,399.4) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 188,383.6 | 185,727.4 | (2,656.2) |
| **Дүн** | **1,596,287.6** | **1,815,783.5** | **219,495.9** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 219,496.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн болон тайлант оны үр дүнгийн эерэг үзүүлэлтээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 2,873,124.6 сая төгрөгийг, үйл ажиллагааны орлогоор 58,450.4 сая төгрөгийг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,037.1 сая төгрөгийг тус тус бүрдүүлж, нийт зарлагыг 2,912,011.4 сая төгрөг, дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх цэвэр зээлийг 20,600.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, сайдын “Төсвийн санал хүргүүлэх тухай” 2023 оны 1/4192 дугаар албан бичгээр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас хөрөнгийн зардлыг 831,180.0 сая төгрөгөөр, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллыг 120,048.0 сая төгрөгөөр, нормативт зардлыг 81,867.9 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 40,686.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 39,455.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 35,147.4 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 24,285.6 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 14,927.8 сая төгрөгөөр, татаасыг 10,341.3 сая төгрөгөөр, албан томилолт, зочны зардлыг 5,226.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3,591.3 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 481.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээг 1,704,772.4 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй, хөрөнгө оруулалтын зардлыг хэт өндөр түвшинд төлөвлөсөнтэй холбоотой бөгөөд төсвийг батлахдаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг танаж, хөрөнгийн зардлыг бууруулсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагч Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгжид төсөвт зохицуулалт хийх хүсэлт албан бичгээр тус тус хүргүүлж, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-д заасны дагуу төсвийн хуваарьт 13 удаагийн өөрчлөлт оруулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүждэг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ, эм, эмнэлгийн хэрэгслийн зардлын дутагдлыг яамны урсгал төсвөөс нэмэгдүүлэн олгох, зохицуулалт хийх эрсдэлтэй байгаа нь тус эмнэлгийн санхүүжилтийн бүтэц, хагас бие даасан байдлыг алдагдуулах, ХЗДХЯ-ны төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлэх эрсдэлийг үүсгэсээр байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсвийг тодотголоор 80,485.3 сая төгрөгөөр бууруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 13 хөтөлбөрийн 58 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,591,548.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 31,686.3 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,052.5 сая төгрөгийг бүрдүүлж, эргэн төлөгдөх цэвэр зээлийн 20,600.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,516,157.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 56,061.9 сая төгрөгийг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1,137.7 сая төгрөгийн санхүүжилт тус тус бүрдүүлж, төсвийн зарцуулаагүй 32,300.6 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,546,807.9 сая төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь урсгал зардлын төсвийг 67,453.7 сая, хөрөнгийн зардлыг 10,113.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулж, дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодоос авах эргэн төлөгдөх цэвэр зээл 20,600.7 сая төгрөгийн төлөлт хийгээгүйтэй холбоотой байна.

Мөрдөн шалгах, шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар батлагдаагүй бусад санхүүгийн түрээс /лизинг/-ийн гэрээ, болзошгүй өр төлбөр үүсгэж байгаа нь дараагийн төсвийн жилийн суурь зарлага, Засгийн газрын нөөц сангийн зарцуулалтыг нэмэгдүүлж байна.

*Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* */сая төгрөгөөр/*

| Д/д | Хөтөлбөр | **Хөтөлбөрийн нэр** | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД** | | | **1,624,375.3** | **1,546,807.9** | **56,966.6** | **96.4** |
| 1 | 70704 | Цагдаа /ЦЕГ+МШУТ/ | 651,975.9 | 639,779.4 | 12,196.5 | 98.1 |
| 2 | 70711 | Шүүгч болон гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах | 11,106.2 | 10,416.0 | 690.2 | 93.8 |
| 3 | 70602 | Хил хамгаалах | 460,910.5 | 450,295.6 | 10,614.8 | 97.7 |
| 4 | 70705 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэл | 234,206.3 | 229,165.2 | 5,041.1 | 97.8 |
| | 70705 | төрийн буруутай | 19,526.9 | 19,526.9 | - | 100.0 |
| 5 | 70406 | Улсын бүртгэл, мэдээлэл | 69,662.7 | 63,178.3 | 6,484.4 | 90.7 |
| 6 | 70707 | Шүүхийн шинжилгээ | 60,368.3 | 49,262.7 | 11,105.6 | 81.6 |
| 7 | 70420 | Цагаачлал, гадаадын иргэдийн бүртгэлийн үйлчилгээ | 18,844.2 | 19,659.0 | (814.8) | 104.3 |
| 8 | 70712 | Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага, зохицуулалт | 32,565.2 | 26,267.6 | 6,297.6 | 80.7 |
| 9 | 70411 | Төрийн архив, албан хэрэг хөтлөлт | 7,102.2 | 7,230.8 | (128.6) | 101.8 |
| 10 | 70710 | Төлбөрийн чадваргүй яллагдагч, сэжигтэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх | 9,393.7 | 6,816.9 | 2,576.8 | 72.6 |
| 11 | 70713 | Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа, шинжилгээ /ХЗҮХ/ | 3,595.4 | 3,562.4 | 33.0 | 99.1 |
| 12 | 70713 | Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа, шинжилгээ /ДХИС/ | 42,713.4 | 38,741.0 | 3,972.4 | 90.7 |
| 13 | 70709 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /ГХУСАЗЗАА | 2,316.3 | 1,785.0 | 531.3 | 77.1 |
| | 70709 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх АСТУСҮАДсан/ | 88.1 | 7,670.5 | (7,582.4) | 8,705.1 |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Баталсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу судалгаа авч, дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Засгийн газрын бүтэц, орон тоог 9 хувиар бууруулах чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нийт 235 байгууллагын орон тоог 1,000.0 бууруулж, 27452 орон тоотойгоор баталж, 119.6 тэрбум төгрөгийн зардлыг бууруулсан байна.
- Ажлын нэг өдрийн хоолны зардлыг 500-10,000 төгрөгөөр 36 байгууллага, 11,000-20,000 төгрөгөөр 76 байгууллага, 22,000-35,000 төгрөгөөр 43 байгууллага тус тус тогтоож, унааны зардлыг 500-4,000 төгрөгөөр 24 байгууллага, 12,500-25,000 төгрөгөөр 4 байгууллага тус тус тогтоож, тайлант хугацаанд хоолны зардалд 47,453.2 сая төгрөгөөр, унааны зардалд 1,212.3 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр хоолны зардалд 42,487.7 сая төгрөг, унааны зардалд 1,019.3 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.
- Сайдын эрхлэх асуудлын хүрээний 15 байгууллага гадаад томилолтын 91 арга хэмжээнд зориулж 428.5 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 91 арга хэмжээнд 628.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс эрх бүхий этгээдээс баталсан тушаал шийдвэргүй 2 арга хэмжээнд зориулж 92.8 сая төгрөгийн гадаад томилолтын зардал гарсан байна.

- Тайлант онд Захиргааны ерөнхий хуулийн 103-т заасан буруутай албан тушаалтны шийдвэрээр ажлаас халагдсан иргэний нэхэмжлэлээр төсвөөс төлбөр төлөгдөөгүй байна.
- Харьяа 235 байгууллагын биет бус хөрөнгийн дансанд 31,929.1 сая төгрөгийн анхны үнэтэй, 27,614.8 сая төгрөгийн 465 программ хангамж, лиценз бүртгэлтэй байна.
- Харьяа байгууллагуудын төсөвт нийт 5,1126 сая төгрөгийн 169 сургалтын зардал батлагдаж, гүйцэтгэлээр 4,881.7 сая төгрөг, үүнээс эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй 98.8 сая төгрөгийн 30 арга хэмжээг зохион байгуулжээ.
- Хууль зүйн салбарын хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай байгуулсан нийт 221.0 сая төгрөгийн ажил, үйлчилгээний гэрээ байгуулсан байна. Үүнээс 76.8 сая төгрөгөөр нийтийн эрх зүйн боловсролыг сайжруулах талаар телевизийн нэвтрүүлэг, богино хэмжээний контентыг хийсэн байна.

### 3.5.3 Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 81,138.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталснаас, гүйцэтгэлээр 77,381.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөснөөс 3,757.6 сая төгрөг буюу 4.6 хувиар дутуу биелсэн байна.

*Хүснэгт 12. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлт* */сая төгрөгөөр/*

| № | Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Улсын бүртгэлийн ерөнхий газар | 45,730.0 | 25,614.6 | 56.0 |
| 2 | Цагдаагийн ерөнхий газар /Жолооны үнэмлэхийн орлого/ | 2,370.0 | 1,428.1 | 60.3 |
| **Улсын төсөвт төвлөрүүлэх орлого** | | **48,100.0** | **27,042.7** | **56.2** |
| 4 | Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого | 33,038.9 | 50,338.6 | 152.4 |
| **Нийт дүн** | | **81,138.9** | **77,381.3** | **95.4** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээр биелсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл улсын төсөвт төвлөрүүлэх орлого 21,057.3 сая төгрөг буюу 43.8 хувиар тасарсан нь УБЕГ-ын лавлагааг цахимаар үнэ төлбөргүй олгосонтой холбоотойгоор орлогын төлөвлөгөөний биелэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

### 3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 80,548.5 сая төгрөгийн нэмэлт орлого, 14,806.7 сая төгрөгийн дээд шатны төсвийн захирагчаас өгсөн санхүүжилт, 12,408.5 сая төгрөгийн аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгө, хандив, тусламжаар 499.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас нэмэлт орлого 26.7 сая төгрөг, нийт 108,289.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс эд хогшил, урсгал засварын зардалд 25,329.4 сая төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 24,789.2 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 18,582.8 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 15,505.1 сая төгрөг, хөрөнгийн зардалд 7,877.9 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 3,809.4 сая төгрөг, нормативд зардалд 3,581.2 сая төгрөг, урсгал шилжүүлэг 2,915.7 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1,400.3 сая төгрөг, томилолт, зочны зардалд 564.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 457.0 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй 4,217.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд 4 төсөл хэрэгжиж байгаагаас 2 төслийн санхүүгийн тайлан донор байгууллагын хэрэгжүүлэх нэгж тухайн улсад тайлагнадаг байна.

*Хүснэгт 13. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт* */сая төгрөгөөр/*

| Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хэрэгжилтийн явц | Төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|
| Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж техник хэрэгслийн хангалт төсөл | 2022-2024 | Хэрэгжиж дууссан /хаалтын тайлан 2025 оны эхний хагас жилээр гарсан/ | - | - |
| Монгол улсын шүүх шинжилгээний чадамжийг сайжруулах | 2021-2025 | Койка -Монгол улсад санхүүгийн тайлан тайлагнадаггүй | - | - |
| Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чадавхыг сайжруулах төсөл | 2021-2025 | ГУХАТ -Монгол улсад санхүүгийн тайлан тайлагнадаггүй | - | - |
| Монгол улсын шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах | 2021-2025 | БНСАУ-ын Эксим банкны хөрөнгө оруулалт төсөл эхэлсэн /зөвлөх үйлчилгээ/ | 3,530.9 | 3,526.7 |
| **Нийт дүн** | | | **38,961.9** | **38,652.5** |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Архивын ерөнхий газрын цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт төсөл нь 2024 оны жилийн эцсээр хөрөнгийг байгууллагад шилжүүлэн өгсөн бөгөөд төслийн сүүлийн гүйлгээ, хаалтын ханшийг талууд тохиролцож хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлохоор Сангийн яаманд хүргүүлж, санхүүгийн тайлангийн хаалтыг хийсэн байна.

### 3.5.6 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд Хууль, зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудал болон түүний харьяа төвлөрүүлэн захирагчдын 13 хөтөлбөрийн 58 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ.

Түүнчлэн тус хөтөлбөрийн гүйцэтгэлийг 50.4 хувь, үр ашгийг 76.6 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагнасан байна.

*Хүснэгт 14. Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт*

| Код | Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин |
|---|---|---|---|---|
| **ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД** | | | | |
| 70704 | Хэргийг хэрэг бүртгэлт явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэхийг 80, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлтийг 85.5, хэргийн илрүүлэлтийг 58, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авсан арга хэмжээг 92 хувьд хүргэсэн байна. | Хэргийг хэрэг бүртгэлт явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэлт | 80.0% | 93.8% |
| | | Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлт | 85.5% | 85.5% |
| | | Хэрэг илрүүлэлт | 58.0% | 48.2% |
| | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авах арга хэмжээний хэрэгжилт | 92.0% | 98.3% |
| 70711 | Гэрч, хохирогчийн хамгаалалтыг 72 хүн, шүүх хурлын танхим, шүүгчийн хамгаалалтыг 100 хувь, шүүгчийн захирамжаар албадан авчрах хувийг 86.1 хувьд хүргэсэн байна | Гэрч, хохирогчийн хамгаалалт | 72 | 134 |
| | | Шүүхийн байрны хамгаалалт | 100.0% | 100.0% |
| | | Шүүх хурлын танхимын хамгаалалт | 100.0% | 100.0% |
| | | Шүүгчийн хамгаалалт | 100.0% | 100.0% |
| | | Шүүгчийн захирамжаар хэрэгжүүлсэн албадлагын арга хэмжээний биелэлт | 86.1% | 86.8% |
| 70602 | Улсын хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог хангаж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улс, олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох зорилгоор хил хамгаалалтад орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, технологийн ололтыг нэвтрүүлнэ. | Хил хамгаалалтад орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх | 5.0% | 5.0% |
| | Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй | Хилийн торон саадын шинэчлэх | 10.0% | 10.0% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилнэ. | | | |
| 70602 | Дэд бүтцийг сайжруулах замаар хилчдийн нийгмийн баталгааг сайжруулна. | Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж, барилга, дэд бүтцийн 50-аас доошгүй хувийг шинэчлэх | 12.0% | 8.0% |
| | | Хилийн салбаруудыг байнгын цахилгааны эх үүсвэрт холбох | 4 | 2 |
| | Хилийн боомтуудад "Дохиолол хяналт, хамгаалалтын нэгдсэн систем"-ийг суурилуулж, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд "Ухаалаг цахим" технологийг нэвтрүүлж, орчин үеийн хяналт шалгалтын техник хэрэгслээр хангана. | Хилийн боомтууд орчин үеийн техник хэрэгслээр хангагдсан байх. | 3 | 3 |
| 70705 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангана. | Хоригдлын хөдөлмөр эрхлэлт | 75.0% | 74.4% |
| | | Мэргэжлийн сургалтад хамрагдах хоригдол | 490 | 1055 |
| 70705 | | Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа | 58.0% | 38.2% |
| | | Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны бодит биелэлт | 84.0% | 62.5% |
| | | Хорих ял эдлэгсэд болон сэжигтэн амбулторийн үзлэгт, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрраргдах | 74.0% | 73.8% |
| | | Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах | 60.0% | 112.0% |
| 70406 | Төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид хүргэх, цахимжуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. | Иргэний үнэмлэх олголт | 300 | 248.3 |
| | | Гадаад паспорт олголт | 350 | 279.2 |
| | | Бэлтгэсэн улсын бүртгэлийн маягт | 1,246.1 | 1204.4 |
| | | Цахим хэлбэрт шилжүүлсэн архивын баримтын тоо /мянгаар/ | 480 | 9300.4 |
| | | Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх | 45,730.0 | 25,614.6 |
| 70707 | Шүүхийн шинжилгээний үйлчилгээг чирэгдэлгүйгээр шуурхай авах нөхцөл бүрдэж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, шинжээчийн дүгнэлтийн чанар, үр дүн дээшилж, бие даасан хараат бус байдал хангагдаж, иргэд үйлчлүүлэгчийн төрд итгэх үнэмшил, сэтгэл ханамжийн баталгаа нэмэгдэнэ. | Эдийн засгийн шинжилгээний дүгнэлт | 100 | 210 |
| | | Шүүх эмнэлгийн шинжилгээний дүгнэлт | 38000 | 57580 |
| | | Криминалистикийн шинжилгээний дүгнэлт | 7000 | 6962 |
| | | Инженер-техникийн шинжилгээ | 800 | 1539 |
| | | Байгалийн ухааны шинжилгээ | 16000 | 18993 |
| 70420 | Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаач иргэний тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно. | Гадаадын иргэнд олгох виз | 7000 | 112895 |
| | | Хяналтад хамрагдах Монгол Улсад түр болон байнга оршин суух гадаад иргэн | 2500 | 6336 |
| 70712 | Монгол Улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлж, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлнэ. | Боловсруулах баримт бичиг, хуулийн төсөл | 26 | 26 |
| | | Хянах эрх зүйн акт | 1000 | 740 |
| 70713 | Цагдаа, Онцгой байдал, Хил хамгаалах, Шүүх шинжилгээ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны хүний нөөц бэлтгэгдэнэ. | Хөтөлбөрүүдэд хамрагдах сонсогч | 2200 | 2,677 |
| 71602 | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үйлчлэх хүрээний иргэн, албан хаагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Амбулаторийн тусламж, үйлчилгээ | 202.7 | 192.9 |
| | | Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ | 11.4 | 9.4 |
| | | Өдрийн эмчилгээ | 1.6 | 2.2 |
| | | Оношилгоо, шинжилгээ | 250 | 111.8 |
| | | Хилийн хөдөлгөөнт бүлгийн үзлэг /мянган/ | 14.4 | 25.6 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 70411 | Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, архивын үйлчилгээавч байгаа аж ахуйн нэгж, байгууллага иргэнд үйлчлэх таатай орчин бүрдэнэ. | Стандартын дагуу бүрдүүлсэн хадгаламжийн нэгжийн тоо /мянгаар/ | 5 | 8.3 |
| | | Хэвлүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэл | 6 | 6 |
| | | Стандартын дагуу дахин боловсруулалт, нөхөн сэргээлт хийсэн хадгаламжийн нэгж /мянгаар/ | 15 | 8.8 |
| | | Стандартын дагуу баяжуулах архивын сан хөмрөг | 10 | 3.3 |
| 70710 | Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагааг хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх гэсэн төрлөөр хэрэгжүүлнэ. | Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл авсан үйлчлүүлэгч | 14000 | 12617 |
| 70710 | | Өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн төлбөрийн чадваргүй үйлчлүүлэгч | 14000 | 12925 |
| 70713 | Хууль сахиулах салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болго, судлаачийн чадавхыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нэмэгдүүлнэ. | Эрх зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулах тоо | 220 | 215 |
| | | Эмхэтгэсэн эрдэм шинжилгээний судалгааны ажил | 45 | 45 |
| 70709 | Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ. | Суурь оны хэрэгжилтийн үр дүнг дараа оны хэрэгжилттэй харьцуулсан өсөлт | 7000 | 7000 |
| | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг сайжруулна. | Суурь оны сургалтад хамрагдсан хүүхдийн тоог дараа оны хамрагдах хүүхдийн тоотой харьцуулсан өсөлт | 7000 | 7000 |
| | Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар малчны мэдлэг, ойлголтыг сайжруулна. | Сургалт, сурталчилгаа хүрэх хүн | 520 | 400 |
| 70709 | Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийн талаарх иргэний хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлнэ. | Сургалт, сурталчилгаа хүрэх хүн | 30000 | 30000 |
| | Олон нийтийн телевиз, радио, сонин сэтгүүл, цахим хуудас зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг өргөн хүрээнд сурталчилж, иргэний хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлнэ. | Сургалт, сурталчилгаа хүрэх хүн | 80000 | 80000 |
| | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна. | Суурь оны хэрэгжилтийн үр дүнг дараа оны үр дүнтэй харьцуулсан өсөлт | 7000 | 6300 |
| | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэл бүхий зорилтот бүлгийн талаар мэдээлэл солилцох дундын мэдээллийн санг үйл ажиллагаандаа ашиглана. | Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагаас дундын мэдээллийн санд хамрагдах байгууллага | 5 | 5 |
| | Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан болон сайн дурын үндсэн дээр эмчлэх эмчилгээний байгууллага, төвийн тоог нэмэгдүүлнэ. | Сайн дураар эмчлэх төв | 3 | 2 |
| 70709 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт ургамлын тархцыг хязгаарлаж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ахиц гаргана. | Суурь оны хэрэгжилтийн үр дүнг дараа оны үр дүнтэй харьцуулсан өсөлт | 5000 | 4000 |
| | Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, хүүхэд | Сургалт, сурталчилгаа хүрэх хүн | 120000 | 120000 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | | | |

*Эх сурвалж: Хууль зүй дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл*

### 3.5.7 Тайлант жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл

Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/08 дугаар тушаалаар урсгал болон хөрөнгө оруулалтын төсвөөр худалдан авах арга хэмжээг баталж, тайлант онд 2025 оны А/239, А/105 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Хууль зүйн салбарын худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 52 арга хэмжээнд 94,190.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 89,797.6 сая төгрөг, урсгал төсвөөр санхүүжих 807 арга хэмжээнд 200,872.1 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 142,528.4 сая төгрөгийн гэрээг тус тус байгуулсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч түүний гадаад, дотоод орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааг сайжруулах харьяа байгууллагуудад илэрсэн зөрчил, дотоод хяналт, үйл ажиллагааны орлого төлөвлөлт, бусад эх үүсвэрийг дайчлах, Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалын хэрэгжилт, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор П.Амарсанаа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 04 дүгээр сарын 02-ний өдрийн 3/1407 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,660,978.0 сая төгрөгийн 1 хувиар буюу 16,609.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дээд шатны төсөв захирагчаас салбарт Төрийн хэмнэлтийн талаар баримтлах бодлого, чиглэл, тушаал, шийдвэр тусгайлан гаргаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” албан даалгаврын дагуу төсвийн хөрөнгийн зарцуулалтыг хязгаарлах, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах зорилгоор төрийн бөгөөд тус албан даалгаварт дотоод, гадаад томилолт зардал, тээвэр шатахууны зардал, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардал, тавилга эд хогшил худалдан авах зардал, багаж тоног төхөөрөмжийн зардал, бичиг хэргийн зүйлс худалдан авах зэрэг зардлыг тэвчих бодлого хэрэгжүүлсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээний зарлагын санхүүжилтийг дараагийн төсвийн жилд шилжүүлэх зэрэг шийдвэрүүд гарсан.

#### 4.3.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох

журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

<u>*Илрүүлэлт 1.*</u> Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 224 байгууллага 2025 онд шилэн дансны мэдээллийн цахим системд нийт 39,945 мэдээлэл байршуулахаас 39,191 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 336 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, нийт 6,179.2 сая төгрөгийн 221 орлого, зарлага, тушаал, шийдвэр, төсвийн гүйцэтгэл, худалдан авалттай холбоотой мэдээллүүдийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.3.3-т “төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 6.4.7-д “байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад тавих дотоод хяналтыг чангатгаж, шилэн дансны мэдээллийн системд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, огт мэдээлээгүй зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

